



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН  
ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА Б.БАДАМСҮРЭН  
ТАНАА**

2014.03.18 № 02/13 ЧАГ-САГ/2014/121/СТГА-ТШЗ

**Зөрчил арилгуулах тухай**


Хан-уул дүүргийн Нийгмийн Халамж Үйлчилгээний Хэлтсийн Халамжийн сангийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар халамжийн сангаас иргэн С.Төгсбаярт нийгмийн халамжийн тэтгэмж 120,000 төгрөгийг, М.Дархижавт 193,000 төгрөгийн рашаан сувилалд амарсан эрхийн бичгийн 50 хувийн нөхөн олговрыг тус тус илүү олгож бүгд 313000 төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т "Халамжийн сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухайн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д заасан "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..." гэсэн заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

Илүү олгосон 120000 төгрөгийг Төрийн банк дахь 102100001819 тоот дансанд, 193000 төгрөгийг ХААН банкны 5022413235 тоот дансанд холбогдох ажилтнуудаар тус тус төлүүлж 2014 оны 4 дүгээр сарын 10-ны дотор буцаан төвлөрүүлэх, Үндэснийн аудитын газарт ирүүлэхийг Хан-Уул дүүргийн Нийгмийн Халамж Үйлчилгээний Хэлтсийн дарга Д.Бадамсүрэн, Халамжийн сангийн мэргэжилтэн Б.Гулзат нарт хариуцуулав.

Аудитор

  
**Ш.Отгонбаяр**  
  
УХА0122